АВТОБУСНЫ ДУГУЙНЫ ТЕХНИК ҮЗҮҮЛЭЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

2025.03.18 Улаанбаатар хот

№	Нэр, төрөл			Yutong	Golden dragon	Dong feng	Hyundai county
1	Дугуйны бренд			Хятад	Хятад	Хятад	Кимно
2	Техникийн үзүүлэлт			275/70R/22.5	11R22.5	9R22.5 дүйцэхүйц	205/75R/17.5
				70,000 км	70,000 км	70,000 км	70,000 км
3	LR/PR тросс			H/16	J/18	H/14	G/14
4	Үйлчилгээний индекц			148/145J	149/146L	136/134K	124/122M
5	Хээний гүн			20	17	14.5	12
6	стандарт хүрээ			8.25	8.25	7	6
7	нийт диаметер			964	1054	1019	753
8	хэсгийн өргөн			276	279	229	205
9	Хүйтэнд даралт ба ачаалалын багтаамж	Дан	kg	3150	3250	2120-2240	1600
			lbs	6940	7160	6175	3525
		Давхар	kpa	900	930	830	750
			(psi)	130	135	120	109
10	Тоо хэмжээ			260	360	60	84
11	Нэгж бүрийн үнэ			700,000	700,000	500,000	650,000
12	Нийт үнэ			182,000,000	252,000,000	30,000,000	54,600,000

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын нийслэлд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх, дотоодын албаны хэрэгцээнд үйлчилгээ үзүүлж байгаа тээврийн хэрэгслүүдэд олон улсын стандартын шаардлага хангасан дугуйны тавигдах шаардлага болон нийлүүлэлт, тоо хэмжээг тусгасан болно.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан Резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарыг хангасан байна.

2. БҮТЭЭГДЭХҮҮНИЙН ЧАНАР, ТЕХНОЛОГИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Нийлүүлэгч нь Тухайн санал болгосон бүтээгдэхүүнийхээ албан ёсны дистрибьютер компани байх.
2. Чанарын сертификаттай байх. Олон улсын стандартын дагуу туршилтад оруулж магадланитгэмжлэгдсэн байх.
3. Үйлдвэрийн, үйлдвэрлэсэн нэр, хаяг, огноо, цэвэр жин заасан гарал үүслийн сертификат, чанарын үзүүлэлтийг хангасан тухай лабораторын шинжилгээний дүгнэлттэй байх.
4. Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавигдах нөхцөлийг нийлүүлэгч тал хариуцна.

5. Дээрх хүснэгтэд заагдсан улиралд ашиглах зориулалттай, автобусны дугуй байна. Хээний гүн даацын дугуйны стандартад заагдсан хэмжээтэй буюу12,5-20 мм-ээс багагүй байна.

3. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан дугуйг нийлүүлнэ.

Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хүлээн авах актыг үйлдсэнээр дугуйг хүлээн авсанд тооцно.

Ачаа хүргэх цэг: СХД-ийн 20 дугаар хороонд байрлах Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын төв оффисд өөрийн тээврийн хэрэгслээр ажлын цагаар тээвэрлэн хүргэх.